

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.02.24

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- ТОП-20 индекс бүх цаг үеийн дээд ханшаа шинэчилсэн ч өнгөрсөн долоо хоногт уналаа.
- Монголын хөрөнгийн бирж хк нэгж хувьцаанд 47₮ ногдол ашиг тараана.
- Багануур хк 20 жилийн дараа ногдол ашиг хуваариллаа.
- Монгол улсын PMI индекс өнгөрсөн онд 58.5 нэгж болж буурлаа.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-2.16%	2.05%	25.47%
MSE A	-2.3%	1.95%	20.27%
MSE B	-0.7%	3.99%	34.89%

2025/02/17 – 2025/02/21

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
KHAN	1,768,539,240.00
GLMT	935,995,575.00
TTL	715,062,620.00
INV	483,774,225.00
TNGR	413,483,715.00

2025/02/17 – 2025/02/21

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
OLL	27.13	19.78%
JLT	75.90	17.86%
NXE	2,639.00	14.99%
SOR	4,181.00	14.99%
ACL	22,020.00	14.99%

2025/02/17 – 2025/02/21

2025 он 02-р сарын 24

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,449

ТОП-20 индекс

52,743

MSE A

20,531

MSE B

15,384



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

4.9%

2024 он

Инфляц

9.6%

2025-01 сар

ГВУН(сая\$)

4,884.28

2025-01 сар

Бодлогын

хүү

10.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.92%

USD/MNT

3,462.59

2025-02-23



Дотоодын зах зээлийн мэдээлэл

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК НЭГЖ ХУВЬЦААНД 47₮ НОГДОЛ АШИГ ТАРААНА

Хуулийн дагуу хувьцаат компаниуд 2 сарын 20-ны дотор 2024 оны санхүүгийн гүйцэтгэлийн тайландаа тулгуурлан ногдол ашиг хуваарилах эсэхээ шийдэх ёстой. Монголын хөрөнгийн зах зээлийн гол тоглогчдын нэг болох тус компани 2024 онд 34.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд үүний 48%-ийг буюу 16.5 орчим тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар болжээ.

Харьцуулбал, 2023 онд тус компани 9.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, 47%-ийг ногдол ашигт хуваарилж байсан нь энэ жилийн ашиг, түүнээс хуваарилах ногдол ашгийн хэмжээ үлэмж өссөн болохыг харуулж байна. Энэхүү шийдвэр зарлагдсаны дараа Монголын хөрөнгийн бирж дээр MSE-ийн хувьцааны ханш 2.60%-иар өсөж, 381.48₮-т хүрэв.



ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК АШГИЙНХАА 44%-ИЙГ НОГДОЛ АШИГТ ХУВААРИЛНА

Санхүүгийн үзүүлэлтүүд:

- Борлуулалтын орлого: +20% өсөлттэйгөөр 41.0 тэрбум төгрөгт хүрэв
- Цэвэр ашиг: +8.1% өсч, 7.0 тэрбум төгрөгт хүрэв. (2023 онд 6.5 тэрбум ₮)
- EPS (нэгж хувьцаанд ногдох ашиг): 5.9 төгрөг


Ногдол Ашиг:

- Нийт ногдол ашиг: 3.1 тэрбум төгрөг
- Нэгж хувьцаанд ногдох ашиг: 2.6 төгрөг
- Цэвэр ашгаас ногдол ашигт хуваарилсан хувь: 44%

График 1. Борлуулалтын орлого (тэрбум төгрөг)



График 2. Цэвэр ашиг (тэрбум төгрөг)




Компанийн борлуулалтын хэмжээ тайлант онд +20 орчим хувиар өссөнөөр 41.0 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашиг нь +8.1%-иар өсөв. 2023 онд 6.5 тэрбумийн ашиг олж байсан ба өнгөрсөн онд 7.0 тэрбум болж нэгж хувьцаанд EPS = 5.9₮-ийн ашиг олжээ.



Дотоодын зах зээлийн мэдээлэл

БАГАНУУР ХК 20 ЖИЛИЙН ДАРАА НОГДОЛ АШИГ ХУВААРИЛЛАА

Багануур" ХК нь 1994 онд МХБ-д бүртгүүлсэн ууган хувьцаат компани бөгөөд 2024 оны санхүүгийн тайлангаар компанийн цэвэр ашиг 1 тэрбум 651 сая төгрөг хүрч, үүнээс 495.5 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар болжээ. Тус компанийн хувьцааны үнэ 2024.01.01-ний 788 төгрөгөөс 2025.02.12-нд 2400 төгрөг болж 304.6%-иар өсжээ.




МОНГОЛ УЛСЫН PMI ИНДЕКС ӨНГӨРСӨН ОНД 58.5 НЭГЖ БОЛЖ БУУРЛАА.

Монгол Улсын Худалдан Авалтын Менежерийн Индекс (PMI) 2024 оны IV улиралд 58.5 нэгж болж, өмнөх улирлаас 2.5 нэгжээр буурсан ч ес дэх улиралдаа тэлэлтийн бүсэд хадгалагдлаа. Үзүүлэлтийн бууралт нь үйлдвэрлэл, ажил эрхлэлт, шинэ захиалгын хэмжээ саарсантай холбоотой байв.



ТОП-20 ИНДЕКСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ



НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Компанийн нэр	Симбол	Бүртгэх өдөр	Нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ
1	Дархан нэхий ХК	NEH	2025-03-10	0.226
2	Багануур ХК	BAN		23.62
3	Барилга корпораци ХК	BRC	2025-03-11	100
4	Хас Банк	XAC		27
5	Төрийн Банк ХК	SBM		63.70
6	Хаан банк ХК	KHAN		195.35
7	Материалимпекс ХК	MIE		150
8	Инвескор ББСБ ХК	INV		60
9	Айтүүлс ХК	ITLS		3.5
10	Мандал Даатгал ХК	MNDL		8.10
11	Улаанбаатар хивс ХК	UBH	2025-03-15	2000
12	Голомт Банк ХК	GLMT		100
13	Сүү ХК	SUU		3.43
14	Таван толгой ХК	TTL		6960
15	Эм Жи Эл Акуа ХК	MGLA	2025-02-25	7.31
16	Гутал ХК	GTL	2025-03-31	2470
17	АПУ ХК	APU		65
18	Инновэйшн инвестмент ХК	QPAY		20
19	Монложистикс Холдинг ХК	MLG		5.4
20	Талх чихэр ХК	TCK		450
21	Би ди сек ХК	BDS		89.67
22	Сэндли ББСБ ХК	SEND	2025-03-15	7.61
23	Монгол Базальт ХК	MBW		2.42
24	Баянгол зочид буудал ХК	BNG		330
25	Тэнгэр Даатгал ХК	TGI		67.12
26	Монос хүнс ХК	MFC	2025-03-12	4
27	Газар Шим Үйлдвэр ХК	GAZR	2025-03-10	2.6
28	Улаанбаатар БҮК ХК	BUK		10
29	Хүрд ХК	HRD		8
30	Тандэм инвэст ББСБ ХК	TAND		1.1
31	Бодь Даатгал ХК	BODI		5
32	Махимпекс ХК	MMX		100
33	Монгол шуудан ХК	MNP		1
34	Монголын хөрөнгийн бирж ХК	MSE		47
35	Гермес центр ХК	HRM	2025-03-07	9.60
36	ЛэндМН ББСБ ХК	LEND	2025-02-26	15
37	Эрдэнэт Суврага ХК	SVR	2025-02-26	5

T+2 төлбөрийн тооцооны системийн дагуу явдаг учир бүртгэлийн өдрөөс 2 өдрийн өмнөх эзэмшлээс тооцдог болохы анхаарна уу